



Helping your child
with literacy and
numeracy at home

Mongolian

Гэртээ хүүхдийнхээ бичиг үсэг болон тооны чадварт нь туслах тухай

NSW муж улсын Боловсролын Яам



Энэхүү гарын авлага нь бага ангийн хүүхдүүдтэй эцэг эх, асран хамгаалагч болон гэр бүлийн гишүүдэд зориулагдсан.

Энэ нь гэртээ суралцахад туслах олон төрлийн дасгал ажилуудаас бүрднэ. Эдгээр дасгал ажлууд нь та хүүхэдтэйгээ сонирхолтойгоор хичээллэхэд мөн сургуулийн гараагаа сайн эхлэхэд нь туслах юм.

Дасгал ажлуудыг идэвхитэйгээр хийн дэлгэрэнгүй судлахад нь хүүхэддээ туслан мөн өөрөөр нь хариулуулж, үзэл бодлоо илэрхийлэхэд нь дэмжээрэй.

Агуулгууд

Бичиг үсгийн чадвар	4
Ярих ба сонсох	5
Унших	10
Зурах ба бичих	16
Тооны чадвар	21
Тоонууд ба тоолох	22
Нэмэх ба хасах	28
Хэв маягууд тодорхойлох болон үүсгэх	32



Бичиг үсгийн чадвар

**Хүүхдийнхээ бичгийн ур
чадварыг хөгжүүлэхэд нь
туслах**

Бичиг үсгийн чадварт сонсох, ярих, унших, бичих болон үсэглэх чадвар орно. Энэ нь бодол санаа, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх мөн ярьж, бичсэн зүйлээс утга санаа гаргах ур чадвар юм.



Ярих ба сонсох

Ярих болон сонсох чадвар нь таны хүүхэд сургуульд сурахад үндсэн суурь болдог. Эдгээр ур чадвар нь хүүхэд бусадтай ярилцах, найз нөхөдтэй болох, болон сургуулийн бүх үйл ажиллагаанд идэвхитэй оролцоход нь тусалдаг.

Хэрвээ та гэртээ хүүхэдтэйгээ Англи хэлээс өөр хэлээр ярьдаг бол хүүхэддээ эх хэлээрээ ярихыг нь үргэлжлүүлэн чухал.

Хүүхэдтэйгээ ярилцах







- **Хүүхэдтэйгээ олон төрлийн сэдвээр ярилцах,** тухайлбал өдөр тутам тохиолддог үйл явдлууд байж болно.
- Өөрийн соёл, түүх болон хүүхдийнхээ тухай **түүхээс хуваалцах.**
- Яг одоо болж байгаа **үйл явдлуудын талаар ярилцах эсвэл дүрслэх.** Жишээ нь “Бид өнөөдөр парк өнгөрөөд сургууль руугаа алхаж байна.”
- **Хүүхдээ сонсон дараа нь тэднийг бас сонгож сургаарай. Харилцан ярианд хэрхэн оролцох,** хэрхэн сонсох мөн оролцдогийг үзүүлэх.
- Хүүхэдтэйгээ ярилцаж асуулт асуухдаа тийм, үгүй гэж хариулахаас илүү дэлгэрэнгүй хариулахаар **асуулт асуух.** Жишээ нь, “Өнөөдөр сургууль дээрээ юу хийсэн бэ?”
- **Хэрхэн эсвэл яагаад** гэсэн асуултуудыг ашиглах. Жишээ нь, “Энэ паркад хэдэн шувуу байна?” гэх мэт.
- Асуулт асуухдаа **хүүхэддээ хариулт өгөх цаг олгоорой.**
- **Харилцан яриагаа сонирхолтой болгох.** Хөгжилтэй түүх зохиох, ярилцах, мөн хүүхэдтэйгээ хамт дуулж болно.

Утга санааг харилцан ойлголцох

- **Үлгэрийг дахин хэлж өгөх.** Үлгэрийн эхэнд, дунд, төгсгөлд юу болсныг ярилцах.
- Уншсаныхаа дараа **гол дүрүүдийн тухай** эсвэл хүүхдийнхээ номын хамгийн дуртай хэсгээс нь **ярилцах.**
- Сургууль руугаа эсвэл тэмдэглэлт арга хэмжээнд очихдоо юу тохиолдож магадгүй тухай **санал солилцох.** Арга хэмжээний дараа юу болсон тухай ярилцаж мөн тэдний сэтгэгдэл болон бодлыг асуух.
- Өөрсдийн төсөөллөөрөө **үлгэр зохиоход нь дэмжих.** “Юуны тухай үлгэр вэ?”, “Үлгэрт хэн хэн гардаг?”, “Үлгэрт юу тохиолддог вэ?” гэх мэтээр асуух.
- **Хүүхэддээ тэдний бүтэн нэр,** гэрийн хаяг, нас, төрсөн өдөр болон утасны дугаарыг **зааж өгөх.**
- Хичээл тарсны дараа өдрийг хэрхэн өнгөрүүлсэн талаар асуух мөн **илүү дэлгэрүүлэн асуух,** тухайлбал “Чамд яагаад тэгж санагдсан юм бол?” гэх мэт.



Таны хүүхдэд англиар ярилцах, үгийн сангаа баяжуулахад нь туслах номнууд



Үгийн сангаа нэмэх

- Ярихдаа тайлбар үгнүүд ашиглах. Хэрвээ таны хүүхэд “Тэнд нохой байна” гэж хэлвэл түүнийг дүрслэн **хэлж өгөх**, тухайлбал, “Тэр жижигхэн, үсэрхэг, цагаан нохой байна” гэх мэт.
- **Хүүхэддээ шинэ үг зааж өгөн** тэдний хэлний мэдлэгийг баяжуулах.
- Хүүхэдтэйгээ хамт уншихдаа **номонд гарсан үгнүүдийн талаар ярилцах**. Үгнүүдийн утгыг хамт ярилцах. Та өөрөө ч сонирхолтой, шинэ үгнүүдтэй таарч болно.
- Шинэ үгээрээ өгүүлбэр зохион **дадлага хийх**.
- Гэрийнхээ доторх эргэн тойронд байгаа эд зүйлээ **шошголон тэмдэглэх**.



Унших

Хүүхэд ном уншуулж, бусадтай хамт уншиж, мөн өөрсдөө уншиж сурдаг.






Өдөр бүр хамт уншин цагийг сонирхолтой өнгөрөөгөөрэй. Сургууль руугаа алхахдаа, номын дэлгүүрт, номын санд мөн хүнсний дэлгүүрт байхдаа ч боломжийг ашиглаарай.

Үлгэр, зохиолын талаар, үлгэрт гарсан хэллэг, үг мөн үсэгнүүдийн дуудлагын тухай ярилцах. Өөрийн төрөлх хэл дээрээ ном унших.

Хүүхэдтэйгээ өдөр бүр унших



- **Хөгжилтэй, сонирхолтой байдлаар унших.** Хүүхдүүд харж, дуурайн, мөн бусадтай харилцан уншиж сурдаг.
- Тэдний дуртай номнуудыг өөрсдөөр нь **сонгуулж, дахин дахин уншуулах.**
- Уншиж эхлэхээсээ өмнө тухайн **номны талаар ярилцах.** Номын гарчиг, юуг өгүүлэх тухай таамаглан ярилцах.
- Номон дээрх **зурагнуудын талаар** болон уг зохиолд ямар холбоотой тухай **ярилцах.**
- Унших явцдаа үлгэрийн талаар **хүүхдээсээ асуулт** асуух, тухайлбал “Одоо юу болох бол?” “Чи яагаад тэгж бодож байна?”.
- Уншсаны дараа тухайн **үлгэрийн талаар ярилцах.** “Үлгэрийн аль хэсэг хамгийн их таалагдсан бэ?” “Аль хэсэг нь сэтгэл хөдөлгөм, хөгжилтэй эсвэл гунигтай байсан бэ?” гэх мэт асуулт асуух.
- Дуртай номоо хүүхэдтэйгээ болон ах, эгч, дүү, найз нартай нь **ээлжлэн унших.**
- **Уншихдаа** сонин, сэтгүүл, зурагт хуудас, гудамжны тэмдэгүүд, хоолны жор болон дэлгүүрээс худалдан авах зүйлсийн жагсаалт гэх мэт **олон төрлийн материалуудаас сонгох.**

Авиа нийцсэн үгтэй англи номнууд



Үгнүүд болон хэллэгүүдийг уншихдаа цагийг зугаатай өнгөрөөх

- **Авиа нийцсэн үгнүүдтэй** болон оньсого таавартай англи номнуудыг сонгох.
- **Авиа нийцсэн үгнүүдийн талаар ярилцах.** Жишээ нь Cat, hat, sat, bat зэрэг үгнүүдийн төгсгөл ижил дуудлагатай тул англи хэлэнд авиа нийцсэн үгнүүд гэдэг.
- **Авиа нийцсэн үгнүүдээр** болон англи хэлний авиа нийцүүлэх тоглоомууд **тоглох.** Авиа нийцүүлсэн өгүүлбэр зохиох, тухайлбал, “Have you ever seen a snail deliver the mail?”.









Үсэгнүүдийн дуудлагыг ашиглан ТОГЛОХ

- Үсэгнүүдийн дуудлагыг ашиглан хөгжилдөх. Ижил дуудлагатай үгнүүдийг ашиглан хөгжилтэй өгүүлбэрүүд зохиох.
- Хүүхэддээ уншиж өгч байхдаа тэдний мэддэг үсэгнүүдийг хуруугаар нь заалган хэлүүлэх.
- Хүүхдийнхээ нэрийг ашиглан **дуудлагын тоглоом тоглох**. “Чиний нэр ямар дуудлагаар эхэлж байна?” “dad гэдэгтэй адилхан эхэлж байна уу?” гэх мэт асуулт асуух.

Англи үсэгнүүдийн тухай номнууд





Зурах ба бичих

Хүүхдээ сонирхолтой зүйлсийн талаар зурж, бичихэд нь дэмжээрэй.

Зурж, бичсэн зүйлсийнх нь талаар хүүхдээрээ яриулах. Яагаад тухайн зүйлийг зурах болсон тухай тэдний яриаг сонирхон сонсох.



Өдөр бүр бичих

- **Сонирхолтойгоор зурж, бичих.** Хийж бүтээх болон тоглох дуртай зүйлсийнх нь талаар зуруулах эсвэл бичүүлээрэй.
- **Бичсэн зүйлийнхээ талаар ярихад нь хүүхдээ дэмжээрэй.** Үүнд тэдний сараачсан зүйл, зурсан зураг, бичсэн үсэг болон үгнүүдийн талаар ярилцаж болно.
- Шохой, харандаа цаас, үзэг маркер гэх мэт **өөр өөр материалыг ашиглан** зурах юм уу бичээрэй.
- Хүүхдээрээ **өөрийнх нь нэрийг бичүүлэх.** Мөн таны хүүхэд чухал хүмүүсийнхээ нэрийг ч бичихийг оролдож болно.
- Хүүхэд зурж эсвэл бичиж байх үед нь **тухайн үсэгнүүдийн дуудлага эсвэл зурж буй зурагных нь тухай ярилцах.**
- Хүүхэд **өөрийнхөө төсөөллөөр** үлгэр зохиоход нь дэмжээрэй. Тэд зураг зурж, үг бичин үлгэрийн ном хийж болно.
- Хүүхдээ **төрөлх хэл дээр нь бичихэд** туслах.





Зорилготойгоор зурах болон бичих

- **Хүүхдээ** дэлгүүрээс авах зүйлсийн талаар, тэдний гэр бүлийнхээ хамгийн хайртай хүний талаар, эсвэл дуртай номных нь талаар **зурж бичихийг нь дэмжээрэй.**
- **Дуу, шүлэг зохиох** мөн түүнд тохирсон үгнүүд бичих эсвэл зураг зурах.
- Хийж байх үед нь юуны талаар зурж, бичиж байгаа тухай **тайлбарлаж өгөхийг гуйгаарай.**
- Найз нөхөд, хайртай хүмүүсдээ өөрт нь тохиолдсон сонирхолтой, хөгжилтэй мөн сэтгэл хөдөлгөм үйл явдлуудын талаар **захиа бичихийг нь дэмжих.**
- Өдөр бүр зурж, бичих **жижиг дэвтэр, журнал, эсвэл тэмдэглэлийн дэвтэртэй байх.**
- Тэмдэглэлт үйл явдал эсвэл онцгой арга хэмжээнд зориулан **мэндчилгээний карт** эсвэл урилга **бэлдэх.**



Утга санааны тухай ярилцах

- Хүүхдээрээ захиандаа оруулах **ямар нэгэн утга санаа бэлдүүлэх**. Энэ нь “Нохойноос болгоомжил” гэсэн утгатай зурагт хуудас эсвэл өөрийнхөө хийх дуртай зүйлсийн талаар багшдаа бичих захиа байж болно.
- Хүүхдийнхээ сонирхол, туршлага, болон өөрсдийн соёлтой холбоотой **өдөр тутмын үгнүүдийг ашиглах**.
- Хүүхдийнхээ бичсэн эсвэл хамтдаа уншсан **үлгэр эсвэл үсэгнүүдийн талаар ярилцах**.
- Ярилцахдаа хүүхдээ **олон төрлийн үг ашиглан өгүүлбэрээр ярихад нь дэмжих**.







Тооны чадвар

Хүүхдийнхээ тооны ур чадварыг хөгжүүлэхэд нь туслах

Тооны ур чадварт бидний өдөр тутмын амьдралд тоо их нөлөөтэй гэдгийг ойлгох чадвар ордог.

Бид өдөр бүр тоонуудыг харж мөн ашиглаж байдаг. Уншиж байхад хуудсан дээр нь тоонууд байдаг, бидний байр дугаартай, мөн бид юм худалдаж авахдаа тоонуудыг нэмж, хасдаг.

Хүүхдээ тооны талаар эерэг хандлагатай болж хөгжихөд нь туслах.

Тооны ур чадвараа өөрсдийн төрөлх хэл дээрээ хөгжүүлэх нь чухал.



Тоонууд ба тоолох

Хүүхдүүдийн хамгийн эхний ур чадвар бол тоолох.

Тоолохдоо:

- Тоонуудыг дарааллаар нь хэлж, санах
- Үсгэн тоонуудыг тохирох тоотой эд зүйлстэй нь олж тааруулах
- Хамгийн сүүлд тоолсон тоо нь нийт зүйлсийн нийлбэр гэдгийг ойлгох.

Ашиглагдах үгнүүд

- урагш тоолох, ухарч тоолох
- өмнөх тоо, дараагийн тоо
- их, бага
- тэнцүү.

Англи тоонууд

0 zero 1 one

2 two 3 three

4 four 5 five

6 six 7 seven

8 eight 9 nine

10 ten



Тоонуудыг сурахад туслах дасгал ажлууд


- Хүүхэддээ тоонууд болон хэмжээг ойлгуулахын тулд **тоо болон цэгтэй шоо ашиглах**. “Шоон дээр хэдэн цэг бусан байна?” гэж асуух.
- Шоо ашиглан тоолдог **ширээний тоглоом тоглох**.
- **Үлгэр уншиж, ярилцах**. Хуудсан дээрх тоонууд болон номон дээрх бусад тоо, хэмжээ, болон тоолох тухай ярилцах.
- **Алхаж байхдаа эргэн тойронд байх тоог олуулах**. “Ямар тоо харж байна?” гэж асуух. Байшингийн тоонууд, машины дугаарууд болон гудамжны тэмдгүүдийн талаар ярилцах.
- Өдөр тутам хэрэглэдэг зүйлс дээрх **тоонуудын тухай ярилцах**. Хүүхэддээ хэрэгтэй тоонуудыг санахад туслах.

Зүйлсийн тоо ширхэг эсвэл цэгнүүдийг таних


Шооны цэгэн хэв маягууд



Цэгэн хэв маягууд



Даалууны цэгэн хэв маягууд



Хүүхэдтэйгээ хамт тоолох



- **Гэртээ юм хийхдээ тоолох.** Амархан жороор хоол хийн хүүхдээрээ орцуудыг нь тоолуулах.
- Гэр бүлээрээ хооллохдоо **хоолны ширээ засахад нь дэмжих.** Хүмүүсийн тоо, ширээн дээр тавих таваг, аяга, сэрээ, халбагуудыг тоолуулах.
- Сургуулийнхаа цамцыг өмсөхдөө хэдэн товч байгааг **хүүхэдтэйгээ хамт тоолох.**
- Өдрийн хоолны саванд нь **хэдэн зүйл байгааг тоолуулах.**
- **Урагш тоолох.** Машин, байшин, гутал, цүнх гэх мэт өдөр тутмын зүйлүүдийг тоолох.
- **Ухарч тоолох.** Шатаар доошоо буун мөн дээшээ гарах. 10, 9, 8

Тоолдог англи дуунууд

- Here is the Beehive
- Five Little Ducks
- The Ants Go Marching
- One, Two, Buckle My Shoe
- Five Cheeky Monkeys Jumping on the Bed
- Ten Green Bottles



Тоонууд болон тоолох тухай Англи номнууд





Нэмэх ба хасах


Бага насны хүүхэд нэмэх, хасахын ойлголттой байх хэрэгтэй. Үүнд хоёр ба түүнээс дээш зүйлийг нийлүүлэх, зүйлсийг хасах мөн салгах орно.

Ашиглагдах үгнүүд

- нийлүүлээд, нэгтгээд, нийлээд
- үүнээс бага эсвэл илүү
- бүгд нийлээд
- авчихвал
- хэдээр илүү олон

Нэмэх ур чадварыг сайжруулах дасгал ажлууд

- Тоглоом, жимс, номнууд зэрэг **өдөр тутмын зүйлсийн хэмжээг нэмэх**. Хүүхдүүд нэмэхдээ хуруугаа ашиглаж болно.
- Алхаж байхдаа хашаан дах цэцэгнүүд зэрэг нүдэнд харагдах **зүйлсүүдийн тоог нэмэх**.
- Календар дээр сургуульд явсан эсвэл ямар нэгэн зүйл хийсэн өдрүүдийг хүүхдээрээ тэмдэглүүлэх. Долоо хоногийн сүүлд **тухайн зүйлийг хэдэн өдөр хийснээ нэмэх**.
- Дэлгүүрт байхдаа юу авах тухайгаа ярилцах. “Хүн бүрт гадил авбал хэдэн ширхэгийг авах хэрэгтэй вэ? Хэрвээ нэгийг илүү авбал хэд болох вэ?” гэх мэт **асуултууд асуух**.
- **Хоёр шоо ашиглан нэмдэг тоглоом тоглох**, жишээ нь “Snakes and Ladders.”







Хасах ур чадварыг сайжруулах дасгал ажлууд

- **Өдөр тутмын зүйлсүүдийг хасах.** Өдрийн хоолны савандах зүйлсээ тоолон дараа нь заримыг нь аван хасах.
- **Идэж байхдаа хэдэн ширхэг зүйлс байгааг тоолох.** “Чи хэдэн ширхэг усан үзэм идсэн бэ? Хэдэн ширхэг үлдсэн бэ?” гэх мэт асуултууд асуух.
- Өндөгнүүдийг савнаас гаргах эсвэл гадилыг багцаас нь салгах зэрэг **зүйлсийг салгахад ямар өөрлөлт гарч байгааг хүүхдээ ажиглахад нь дэмжих.**
- “Five Little Ducks” зэрэг нэгийг авахад тоо нь багасдаг **дуунууд дуулах.**
- “Аяганд 5 алим байна. Хэрвээ би хоёрыг идчихвэл хэд үлдэх вэ?” зэрэг **асуултууд асуух.**

Нэмэх болон хасах тухай Англи номнууд






Хэв маягууд тодорхойлох болон үүсгэх

Хэв маяг гэдэг нь давтагдсан бүрдэл юм. Энэ нь дүрс, дуу чимээ, тоо эсвэл эд зүйлс байж болно.

Хүүхдүүд өдөр тутмын үйл ажиллагаагаараа хэв маягуудыг таних, тодорхойлох, үүсгэх, дуурайх, мөн хэв маягийг үргэлжлүүлж сурдаг.





Ашиглагдах үгнүүд

- давтах
- үргэлжлүүлэх
- шинээр бий болгох
- олж нээх, илрүүлэх
- тайлбарлах
- хээ, маяг
- ижил, адил
- өөр

Хэв маягуудыг таних болон тодорхойлох


- Бэлэгний цаас, угаалгын өрөөний пильта болон зам дээрх **хэв маягуудыг тодорхойлох**. Олон төрлийн хэв маягууд болон тэдгээр нь хэрхэн хэв маяг болж байгааг ярилцах.
- **Хээ маягийн талаар ярилцах**. “Яагаад ийм хээтэй байгаа юм бол?”, “Энэ хээ маягийг чи үргэлжлүүлж чадах уу?” гэх мэтээр асуугаарай
- **Карт, даалуу эсвэл шоотой тоглоом** тоглож хүүхэддээ хэв маягуудыг танихад туслах.

Хэв маягуудыг дуурайх





- Алга ташин хэв маяг үүсгэн хүүхдээ дуурайлгах алга ташдаг тоглоом тоглох. Хүүхдээрээ алга ташуулан хэв маяг үүсгэн та өөрөө дуурайгаарай.
- Хамтдаа хоолныхоо ширээг засан таваг ба халбага, таваг ба халбага, таваг ба халбага гэсэн хэв маяг үүсгээрэй.

Хэв маягууд үүсгэх

- Тоглоом болон жимс зэрэг өдөр тутмын зүйлсээр хэв маягууд үүсгэх.
- Энгийн хэв маяг эхлэн үүсгэж түүнийгээ улмаар ярвигтай болгох. Жишээлбэл, нэг алим, хоёр гадил, нэг алим, хоёр гадил, нэг алим хоёр гадил гэх мэт.



Хэв маягуудын тухай Англи номнууд





Таны хүүхдэд англи хэлний бичгийн ур чадварыг хөгжүүлэх номнууд

Харилцан яриа болон үгийн санг нэмэгдүүлэх номнууд

Dunbi the Owl – Daisy Utemorrah, editor Pamela Lofts. Scholastic Australia

Possum Magic – Mem Fox, illustrator Julie Vivas. Omnibus Books

Splash for the Billabong – Ros Moriarty, illustrator Balarinji. Allen and Unwin

The Day the Crayons Quit – Drew Daywalt, illustrator Oliver Jeffers. Harper Collins Children's Books

The Echidna and the Shade Tree – Mona Green, editor Pamela Lofts. Scholastic Australia

The Little Refugee – Anh and Suzanne Do, illustrator Bruce Whatley. Allen & Unwin Children

The True Story of the 3 Little Pigs – Jon Scieszka, illustrator Lane Smith. Penguin

The Very Cranky Bear – Nick Bland. Scholastic Australia

Авиа нийцсэн үгтэй номнууд

Miss Spider's Tea Party – David Kirk. Scholastic Inc

No Way Yirrikipayi! – Alison Lester. Pan Macmillan Australia

Pig the Pug – Aaron Blabey. Scholastic Australia

Piranhas Don't Eat Bananas – Aaron Blabey. Scholastic Australia

Oi Cat! – Kes Gray, Jim Field. Hachette Australia

Sebastian Lives in a Hat – Thelma Catterwell, illustrator Kerry Argent. Omnibus Books

Walking Through the Jungle – Stella Blackstone. Barefoot Books

The Cat in the Hat – Dr Seuss. Random House

Үсэгнүүдийн тухай номнууд

ABC Dreaming – Warren Brim. Magabala Books

Animalia – Graeme Base. Picture Puffins

Dr Seuss's ABC – Dr Seuss. Random House

I Spy, An Alphabet in Art – Lucy Micklethwait. Greenwillow Book

Жагсаалтанд орсон номнуудыг бичгийн болон тооны ур чадварыг сайжруулах олон төрлийн зорилгоор ашиглаж болно.

Манай вэбсайтаар зочлон нэмэлт материалуудыг олж болно. Ингэснээр та хүүхдээ сургуулиа сайн эхэлж амжилттай суралцахад нь туслах болно.

education.nsw.gov.au/lit-and-num-at-home



Таны хүүхдэд тооны ур чадварыг хөгжүүлэх Англи номнууд

Тоо болон тоо тоолох тухай номнууд

Counting on Community – Innosanto Nagara. Seven Stories Press, Penguin.

Counting with Tiny Cat – Viviane Schwarz. Walker Books

Five Little Ducks – Penny Ives. Child's Play International Ltd

One is a Snail, Ten is a Crab – April Pulley Sayre and Jeff Sayre, illustrator Randy Cecil. Scholastic Australia

One Woolly Wombat – Kerry Argent. Scholastic Australia

Ten Black Dots – Donald Crews. Scholastic Australia

Ten Little Dinosaurs – Mike Brownlow, illustrator Simon Rickerty. Orchard Books

Ten Little Jarjum – Tabulam Aboriginal Community members, editors Suzi Williams and Kate Merrifield. NSW Board of Studies

Ten Scared Fish – Ros Moriarty, illustrator Balarinji. Allen and Unwin

Нэмэх болон хасах тухай номнууд

Five Little Monkeys Play Hide-and-peek – Eileen Christelow.
Houghton Mifflin

Ten Little Beasties – Rebecca and Ed Emberley. Macmillan

Ten Little Fingers and Ten Little Toes – Mem Fox, illustrator Helen Oxenbury. Puffin Books

Ten Little Ladybugs – Melanie Gerth, illustrator Laura Huliska-Beith. Intervisual Books Inc

There Were 10 in the Bed – illustrator Wendy Straw. Sweet Cherry Publishing

The Shopping Basket – John Burningham. Random House

Uno's Garden – Graeme Base. Penguin Books, Puffin

Хэв маягуудын тухай номнууд

Anno's Counting Book – Mitsumasa Anno. Harper Collins

Caterpillar and Butterfly – Ambelin Kwaymullina. Fremantle Press

One fish, two fish, red fish, blue fish – Dr Seuss. Random House

The Very Hungry Caterpillar – Eric Carle. Hamish Hamilton Press

© State of New South Wales (Department of Education), 2020.

The copyright material published in this resource is subject to the Copyright Act 1968 (Cth) and is owned by the NSW Department of Education or, where indicated, by a party other than the NSW Department of Education (third-party material).

Copyright material available in this resource and owned by the NSW Department of Education is licensed under a Creative Commons Attribution 4.0 International (CC BY 4.0) licence. This licence allows you to share and adapt the material for any purpose, even commercially.

Attribution should be given to © State of New South Wales (Department of Education), 2020.

Material in this resource not available under a Creative Commons licence:

- the NSW Department of Education logo, other logos and trademark-protected material
 - material owned by a third party that has been reproduced with permission.
- You will need to obtain permission from the third party to reuse its material.

Утсан орчуулгын үйлчилгээ

Хэрэв танд нэмэлт мэдээлэл хэрэгтэй бол сургуулийн захиралтай холбогдоорой. Хэрэв танд орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний төвтэй 131 450 дугаараар холбогдон өөрийн хэл дээр орчуулгын үйлчилгээ авч болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй болно.